



## "СУУГУУЛ НУТГААС УУГУУЛ НУТАГТАА" ГЕРМАН ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

2015 оны 3 дугаар сарын 24

Берлин хот

"СУУГУУЛ НУТГААС УУГУУЛ НУТАГТАА" Герман дахь Монголчуудын чуулга уулзалтыг Берлин хотноо 2015 оны 3 сарын 5-наас 6-ны өдрүүдэд Монгол улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны ивээл дор, ХБНГУ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөн хөгжлийн төвийн (CIM/ОУШХХТ) дэмжлэгтэйгээр Монгол-Германы эдийн засгийн клуб ТББ ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний зорилго нь ХБНГУ-д шилжин суурьшсан Монголчуудын хоорондын харилцаа, тэдний үүсгэн санаачилсан байгууллагын эх нутаг руугаа чиглэсэн бүтээмжит хамтын ажиллагааг дэмжих, мэдлэг туршлагыг уугуул нутагтаа түгээх, хилийн чанад дахь Монголчуудын хүч нөөцийг эх орны хөгжилд татан оролцуулах, эргэн суурьшилтын төрийн бодлогод оновчтой санал санаачилгыг дэвшүүлэх явдал байлаа.

Чуулга уулзалтанд Монгол улсын төр засаг, ЭСЯ-ны төлөөлөгчид, CIM/ ОУШХХТ-ийн төлөөлөгчид, ХБНГУ-ын Муж улс бүрийн монгол болон монгол-германы ТББ-ууд, ХБНГУ-д шилжин суурьшиж, мэргэжлийн салбартаа амжилттай ажиллаж буй монголчууд, оюутан залуусын төлөөлөл нийт 120 гаруй төлөөлөгчид оролцлоо.

Арга хэмжээний үеэр УИХ-ын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Монгол улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ц.Болор, ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, мэдээллийн газрын захирал Х.Мандахцэцэг, ХБНГУ-ын ОУШХХТ-ийн багийн ахлагч Р. Занфтенберг, ОУШХХТ-ийн Монгол дахь зөвлөх мэргэжилтэн С.Сайнсөр, эдийн засагч, телевизийн ДэФакто нэвтрүүлгийг зохион байгуулагч Д.Жаргалсайхан зэрэг төлөөлөгчид оролцож үг хэлж, илтгэл тавьсан нь чуулганыг улам ач холбогдолтой болголоо.



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und



## ЧУУЛГАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ДАРААХ АЖЛУУД ХИЙГДЛЭЭ.

### 2015 оны 3-р сарын 5-ны өдөр

Герман дахь монгол болон монгол-германы ТББ-уудын Зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулав. Хурлын ажиллагаанд Монгол улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ц. Болор, Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл нар оролцож “Найрсаг Улаанбаатар хөтөлбөр”-ийн талаар танилцуулсан.

### 19.00- 21.00 цаг

Эдийн засагч, телевизийн ДэФакто нэвтрүүлгийг зохион байгуулагч Д.Жаргалсайхантай чөлөөт уулзалт хийж уулзалтанд ХБНГУ-д амьдарч байгаа 50 гаруй монгол иргэд оролцон "Монгол орны эдийн засаг, улс төрийн өнөөгийн байдал" сэдвээр хэлэлцэн сонирхолтой ярилцлага зохион байгуулсан.

Оюуны их нөөцтэй, боловсролын өндөр твшинтэй, эдийн засаг, шинжлэх ухаан, техник өндөр хөгжсөн, хүмүүс нь бүтээх хөдөлмөрлөх онцгой чадвартай, өндөр зохион байгуулалттай, аливаа хууль дүрэм зааврыг аль ч насны хvмvvc нь чанд мөрддөг, эдийн засаг, санхvвгийн асар их нөөц бүхий бидний суугуул нутаг Герман орноос суралцах, уугуул нутагтаа нэвтрүүлэх зүйл их байгаа талаар сонирхолтой хэлэлцүүлгүүд явагдсан болно.

### 2015 оны 3-р сарын 6-ны өдөр

### 09.00-20.00 цаг

Чуулга уулзалт Саксен-Анхальт муж улсын Берлин хот дахь төлөөлөгчийн газрын байранд зохиогдсон бөгөөд Монгол улсын төр засаг, ЭСЯ-ны төлөөлөгчид, CIM/ОУШХХТ-ийн төлөөлөгчид, ХБНГУ-ын Муж улс бүрийн монгол болон монгол-германы ТББ-ын төлөөлөгчид, Герман улсад сурч, ажиллаж, амьдарч байгаа Монголчуудын төлөөлөл нийт 120 гаруй хүн оролцож эх орныхоо хөгжилд өөрсдийн хувь нэмрээ оруулах боломжийн талаар санал солилцон, идэвхтэй хэлэлцүүлэг явагдлаа.

### 09.00 - 12.30 цаг

Чуулганы нэгдсэн хуралдаан явагдсан.

УИХ-ын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Монгол улсаас ХБНГУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und



Ц.Болор, ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, мэдээллийн газрын захирал Х.Мандахцэцэг, ХБНГУ-ын ОУШХХТ-ийн багийн ахлагч Р. Занфтенберг, ОУШХХТ-ийн Монгол дахь зөвлөх мэргэжилтэн С.Сайнсөр, эдийн засагч, телевизийн ДэФакто нэвтрүүлгийг зохион байгуулагч Д.Жаргалсайхан зэрэг төлөөлөгчид үг хэлж, илтгэл тавьсан.

### 13.30-16.30 цаг

-Эрүүл мэнд

-Боловсрол

-Ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгаалал сэдвүүдээр салбар хуралдаанууд тус тус зохион байгуулагдсан.

### 16.45-18.15 цаг

Салбар хуралдаануудын товч тайлан тавигдаж дараа нь салбар бүр дээр нэмэлт асуулт хариулт явагдсан болно.

### 18.30 - 20.00 цаг

Чуулганд оролцогчид оройн зоогны үеэр чөлөөт ярилцлага хийж чуулга уулзалтын арга хэмжээ маш үр дүнтэй, амжилттай явагдаж дууссан.

## **Дүгнэлт**

Дээрх арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Монгол улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам, ХБНГУ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөн хөгжлийн төвд нийт оролцогчдын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

Өндөр хөгжилтэй Герман оронд сурч, ажиллаж, амьдарч байгаа монголчууд бид эх орныхоо хөгжил дэвшилд нэмэр болохуйц санал санаачлага, дэвшилтэт арга барил, техник технологи, ноу хау, герман хүний ажилд хандах хандлага гээд олон зүйлийг суралцаж нэвтрүүлэх талаар харилцан санал болон туршлага солилцох боломжийг энэхүү арга хэмжээ бидэнд олголоо.

Германд сурч, ажиллаж, амьдарч байгаа монголчууд эх орныхоо хөгжилд нэмэр болохуйц санаа, зөвлөмжийг гаргах, харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зорилгоор эрүүл мэнд, боловсрол, уул уурхай, ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгааллын чиглэлээр ажлын хэсгүүд



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus gliz und



байгуулан ажиллах саналыг салбар хуралдаанд оролцогчид санал нэгтэй дэмжлээ.

Цаашид шинэлэг санаа, зөвлөмжийг дээрх ажлын хэсгээр хэлэлцсэний дараа нэгдсэн байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлж байхаар тохирсон болно.

Чуулганд оролцогчид санаа оноогоо хэлэлцэхэд цаг хугацаа хангалттай хүрэлцэхгүй байсан нь цаашид энэ төрлийн уулзалт арга хэмжээг тогтмолжуулах хэрэгцээ, шаардлага байгааг харууллаа.

Герман улсад ажиллаж, амьдарч, сурч буй иргэд бид эх нутагтаа эргэж очих эсвэл суугаа орноосоо эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулах эрмэлзлэл дүүрэн байдгаа энэхүү арга хэмжээний үеэр илэрхийлж байлаа.

Гадаадад байгаа монголчуудаа төр засгаас анхаарч үзэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх талаар хууль батлан гаргах, дэмжлэгийн зориулалттай тусгай сан байгуулах, тэдний эрх ашгийг хамгаалах, эргэн суурьших тохиолдолд хуулийн болон бусад зөвлөлгөө, зааварчилгаа өгдөг байгууллагатай болгох зэрэг саналыг ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, мэдээллийн газраар дамжуулан уламжлахаар тогтов.

Жич: Салбар хуралдаануудын тайланг хавсаргав.

Хавсралт 1. Эрүүл мэнд

Хавсралт 2. Боловсрол

Хавсралт 3. Ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгаалал

Хувийг: МУ-аас ХБНГУ-д суугаа ЭСЯ-нд

Олон улсын шилжилт хөдөлгөөн хөгжлийн төвд

Герман дахь монгол болон монгол-германы ТББ-уудын Зөвлөлд

МОНГОЛ ГЕРМАНЫ ЭДИЙН ЗАСГИЙН КЛУБ ТББ



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und



“Суугуул нутгаас –Уугуул нутагтаа” чуулганы хүрээнд зохиогдсон

## БОЛОВСРОЛЫН САЛБАР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Тус салбар хуралдааныг 2015-оны 3-р сарын 06-ны өдрийн 14.30-17.00 цагийн хооронд Саксен-Анхальт муж улсын Берлин хот дахь төлөөлөгчийн газрын байранд зохион байгуулав.

Хурлын тэргүүнээр Т.Болдгэрэл ажиллаж хурлын үйл ажиллагааг Ю.Болд хөтлөн явуулав. /Оролцогчдын нэрсийн жагсаалтыг хавсаргав/

Илтгэгч: Др. Д.Гүнцэцэг

Илтгэлийн нэр: Ерөнхий боловсролын салбар дах хамтын ажиллагааны нөөц

Илтгэгч: Оюунтүлхүүр

Илтгэлийн нэр: Монгол хэл төсөл

Илтгэгч: Т.Болдгэрэл

Илтгэлийн нэр: Мэргэжлийн боловсрол – бүтээн байгуулалтын гарц

Илтгэгч: Др. Д.Хишигбаяр, Др. С.Олонбаяр

Илтгэлийн нэр: Дээд боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд бидний оролцоо

Салбар хуралдаанд 40 гаруй төлөөлөгчид оролцов. Хурал нээлттэй бөгөөд ажил хэрэгч уур амьсгалд болж доорхи саналуудыг дэвшүүлэв.

### **1.Ерөнхий боловсрол:**

- ЕБС –ийн түвшинд сурагчдын солилцоог эрчимжүүлэхэд ХБНГУ-д үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд идэвхтэй оролцон монголын өсвөр үеийхэнд Герман улс, түүний бүхий л талын түүх, хөгжлийг ойртуулах замаар тэдний Германд суралцаж боловсрол эзэмших сонирхлыг төрүүлэх мөн Германд суралцаж буй монгол хүүхдүүд, өсвөр үеийхнийг эх нутгийн үе тэнгийнхэнтэй ойртуулан нөхөрлүүлэх



- Монголын ерөнхий боловсролын сургалтын чанар чамлахааргүй зарим үзүүлэлтээр сайн ч бид олон улсын түвшинд чухам ямар үзүүлэлттэй байгаагаа тодорхойлох шаардлагатай.  
Энэ үүднээс манай улс Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага /OECD – Organisation for Economic Cooperation and Development /-с түүний гишүүн болон гишүүн бус орнуудын ерөнхий боловсролын сургалтын түвшинг тогтоодог „PISA“ /Programm for International Student Assessment /- судалгаанд хамрагдах. Энэ судалгаанд Монгол Улс сайн үзүүлэлт гаргах аваас манай орны ерөнхий боловсролын тогтолцоо, түүний чанар олон улсад хүлээн зөвшөөрөгдөх том үзүүлэлт болохоос гадна монгол залууст гадаад оронд суралцахад жишээ нь ХБНГУ-д суралцахад тавигдаж буй өндөр босго үзүүлэлтүүд хөнгөрөх юм. Таагүй үзүүлэлт гарах аваас энэ нь манай боловсролын салбарт зайлшгүй өөрчлөлт хийх том дохио болох учиртай.
- ЕБС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, тэдэнд германы болон европын мэргэжил нэгтнүүдээс нь туршлага судлах ажлуудыг зохион байгуулах
- Хүүхдийн хөгжлийн хөтөч болсон эцэг эхийн оролцоог ерөнхий боловсрол эзэмших үйл ажиллагаанд идэвхжүүлэх. Монгол Улсын боловсролын яамнаас хэрэгжиж буй “Ном” хөтөлбөрийн хүрээнд ном унших арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулах

## **2. Мэргэжлийн боловсрол сургалт**

- Аливаа орны хөгжлийг гардан бүтээн байгуулагч ажиллах хүчийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ААН-ийн оролцоотойгоор төрийн дэмжлэгтэй зохицуулан явуулах нь мэргэжлийн боловсрол сургалтын эрүүл тогтолцоо болохын үлгэр жишээг Герман улсын мэргэжлийн сургалтын хос/мог/ тогтолцоо харуулж байна.  
Манай улсын ААН эрхлэгчдэд чадварлаг, найдвартай, тогтмол ажиллах хүчинтэй байх улмаар залуу халаагаа бэлтгэх явдал нь тэдний өөрсдийн идэвхтэй оролцоо, нийгмийн хариуцлагаар хэмжигдэх ёстой нь тэр бүр ухамсарлагдаагүй байгаа билээ.  
Иймээс Герман улсад сурч, ажиллаж буй Монгол иргэд уугуул нутагтаа хувийн хэвшил байгуулах, германы ААН-ийн төлөөлөл болох эсвэл герман түншүүдтэй хамтарсан ААН байгуулах зэрэг ямар ч хэлбэрийн бизнес үйл ажиллагаа эрхэлсэн мэргэжлийн боловсролын сургалт эзэмшүүлэгч, дадлагажуулан сургагч үлгэрлэгчид байхыг уриаллаа.



Мөн мэргэжлийн боловсролын чиглэлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж буй одоогийн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цар хүрээг өргөжүүлэхэд Төр засгийн зүгээс бодлогын чанартай дэмжлэг гаргах хэрэгцээ шаардлага зайлшгүй байгаа тул энэ тал дээр өөрсдийн хувь нэмрийг оруулан ажиллахад бэлэн буй ба цаашид ажил хэрэг болохуйц санал дэвшүүлж ажиллахаар болов.

### **3. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын өрсөлдөх чадвар**

Эл сэдвээр илтгэл тавьсан хоёр эрдэмтэн судлаачид эх орныхоо их дээд сургуульд суралцан улмаар тэндээ багшилж байгаад ХБНГУ-д ирж дахин суралцаж, судалгааны ажил хийж эрдмийн зэрэг хамгаалан тус улсын судалгааны институтэд ажиллаж байгаа хоёр орны их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар бодит туршлага хуримтлуулсан илтгэгчид байсан тул хуралдаанд оролцогчдын сонирхлыг татсан, чанартай илтгэлүүд тавигдаж доорхи саналуудыг дэвшүүлэв:

- Ирээдүйн техник, технологийн судалгааг Монгол улсдаа эрчимтэй нэвтрүүлэх
- Боловсрол даяарчлагдаж буй энэ эрин үед манай улсын их дээд сургуулиуд олон улсын стандартад сургалтын агуулга, суралцах орчин бүхий л талаар хүрэх шаардлагатай, ялангуяа мэдээллийн технологи, техник чиглэлээр олон улсын түвшинд хүрэхэд энэ чиглэлээр гадаадад буй монгол эрдэмтэд монгол оюутнууд, залуу судлаачдыг дэмжин ажиллах. Европт мэдээлэл холбооны технологийн салбарт ажиллаж буй Монголын мэргэжилтэн судлаачид, эрдэмтдийн "Mongolian High Tech Group"-үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Олон улсад нэр хүнд бүхий сургуулиудад бакалавр-аар суралцагчдад ЗГ-аас их хэмжээний сургалтын тэтгэлэгт зарж буй мөнгийг багш нарын мэргэшил, судалгааны ажилд зарцуулах замаар дээрхи шаардлагуудыг хангах

### **Хурлаас гарах дүгнэлт:**

Германд сурч, ажиллаж буй монголчууд бид эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах чин эрмэлзэлтэй байдаг нь хурлын явцад улам тодорхой харагдаж байлаа.



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und 





Хурлын цаг давчуу байсан учир илтгэлүүдийн дараа асуулт, хариулт, хэлэлцүүлэг явуулах хугацаа хүрэлцэхгүй байсан нь цаашид энэ төрлийн уулзалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байгааг харууллаа.

"ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН АГУУЛГА, АРГА ТЕХНОЛОГИ, БАГШИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ" сэдэвт бага хурал 2015-оны 5-р сарын 07-09-ний өдрүүдэд МУ-ын Боловсрол, соёл шинжлэх ухааны яамнаас зохион байгуулагдах тул "Суугуул нутгаас –Уугуул нутагтаа" арга хэмжээний үеэр тавигдсан эл сэдвийг хөндсөн илтгэлүүдийг оролцуулах нь зүйтэй.

Нөгөө талаар хэлэлцүүлгийн үеэр санал гаргаж буй зарим оролцогчид хэт ерөнхий санал гаргах, Германд ийм байдаг учраас манай улсад бас ийм байх учиртай хэмээн тулгах, асуудалд зөвхөн нэг өнцгөөс харсан байдлаар хандах явдал ажиглагдаж байлаа.

Бид цаашид тодорхой зардал, цаг хугацаа, бэлтгэл ажил шаардсан, Төр засгийн төлөөлөгчид, гадаадад ажиллаж, сурч амьдарч буй иргэдийн асуудал хариуцсан тодорхой албаны хүмүүс болон салбар бүртээ амжилттай ажиллаж буй олон монголчууд оролцсон ач холбогдол бүхий үүнтэй ижил төстэй арга хэмжээнд оролцон санал хүсэлт дэвшүүлэхдээ эх орондоо болж буй нийгэм, улс төр, эдийн засгийн өдөр тутмын асуудлууд болон Төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүд, төслийн талаар дэлгэрэнгүй мэдээллээр өөрсдийгөө тогтмол хангаж байх, тодорхой хөтөлбөртэй уялдуулан түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх шийдэл, арга замаа тодорхойлсон санал гаргаж байх нь чухал байна.

Боловсролын салбар хуралдааны дараа тус хуралдаанд оролцогчид цаашид уугуул нутаг руугаа чиглэсэн хамтын ажиллагаа явуулах зорилгоор саналаа нэгтгэн ажлын хэсгүүд байгуулах, оюутан залуусын зүгээс хурлын илтгэгчид болон хуралд хүрэлцэн ирсэн тухайн салбартаа амжилттай ажиллаж буй мэргэжилтнүүдтэй холбоо тогтоон зөвлөлгөө, удирдамж авах, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох боломжийг эрэлхийлэх зэргээр байнга хамтран ажиллах талаар санал гаргаж дээрх саналуудаа ажил хэрэг болгохыг санал нэгтэй дэмжлээ.

Хурлын тэмдэглэл хийсэн

Т.Болдгэрэл



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und





## “СУУГУУЛ НУТГААС УУГУУЛ НУТАГТАА” чуулга уулзалтын Эрүүл мэндийн салбар хуралдааны тайлан

Эрүүл мэндийн салбар хуралдаанд нийт 21 төлөөлөгч оролцсоноос 9 эмч, 7 эрүүл мэндийн салбарын ажилтан болон Монгол улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны ажилтнууд мөн ОУШХХТ-ийн төлөөлөгчид байлаа.

Хуралдааныг нээж Берлин хот дахь Аугустэ-Викториа-Клиникийн эмч Д.Эрдэмбаяр үг хэлсний дараа хуралд оролцогчид өөрсдийгөө танилцуулав.

### Хуралдаан дээр тавигдсан илтгэлүүд:

1. М.Туул, Шүдний эмч, “Хил хязгааргүй шүдний эмч нар” сангийн ерөнхийлөгч, Нюрнберг хот.

Сэдэв: “Хил хязгааргүй шүдний эмч нар” /DWLF/ сангийн түүхэн замнал болон 2007-2014 оны хооронд Монгол улсад үзүүлсэн тусламж

2. Д. Насанбат, Халле хотын Diakonie Krankenhaus, сэхээн амьдруулах тасгийн удирдах эмч

Сэдэв: ХБНГУ-д ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэрэгжилтнүүдээс Монгол улсын Эрүүл мэндийн салбарт үзүүлж болох хөрөнгө оруулалтын боломжууд

3. Д.Эрдэмбаяр, Берлин хот дахь Аугустэ-Викториа-Клиник, Гар сарвуу, гоо сайхан болон согогийн тасгийн эмч

Сэдэв: ХБНГУ-аас 2014 оныг хүртэл Монгол улсын эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа болон хэрэгжсэн мөн хэрэгжиж чадаагүй төслүүдийн танилцуулга.

Илтгэл тус бүрийн дараа 20-25 минутын асуулт хариултууд явагдаж оролцогчид илтгэл тус бүр дээр санал бодлоо гаргаж саналаа солилцов.

Салбар хуралдааны төгсгөлд хуралд оролцогчид салбар хуралдаанаас гарсан шийдвэр болон санал хүсэлтүүдийг Монгол улсын Засгийн газарт хүргэх нь зүйтэй хэмээн санал нэгтгэйгээр шийдвэрлэв.



## **Салбар хуралдаанаас гарсан санал болон хүсэлтүүд:**

1. ХБНГУ-д нарийн мэрэгжил эзэмшсэн Монгол эмч нарын Монгол улсад ажиллах Лицензийн асуудлыг хөнгөвчилж өгөх.
2. Улаанбаатар хотын Эрүүл мэндийн хөгжлийн төвтөй хамтарч интернет форум үүсгэх, хамтарч ажиллах мөн цаашлаад Онлайн сургалт явуулах.
3. ХБНГУ-дах Монгол эмч нарын Холбоо байгуулах ( энэ талаар 2 сарын дараа Германы төв орчимд Германд ажиллаж амьдарч байгаа эмч, эмнэлгийн ажилтан болон эрүүл мэндийн салбарын ажилтнуудын уулзалтыг зохион байгуулах)
4. Монгол улсад гаднаас өгч байгаа тусламжын бараа, тэр тусмаа эрүүл мэндийн салбарын, эмнэлгийн багаж төхөөрөмжийг оруулах журам тогтоолыг манай улсын холбогдох байгууллагууд дахин хэлэлцэх, улмаар тусламж үзүүлж байгаа талд аль болох хялбар болгох талаар саналаа хүргүүлэх гэсэн дээрх саналуудыг салбар хуралд оролцогчид гаргасан болно.

Тайлан бичсэн

Д.Эрдэмбаяр



## САЛБАР ХУРАЛДААН

### НОГООН ХӨГЖИЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛ

**Проф. Др. Инж. Шаравын Бүрэн**

**Фраунхофер институт**

**Илтгэлийн нэр: Төв Азийн Усны нөөцийн нэгдсэн менежмент „Загвар бүс-Монгол“**

2003-аас 2017-оны хооронд 3 үе шаттайгаар Дархан хотод хэрэгжиж буй төв цэвэрлэгээний төхөөрөмжийн шинэчлэл, усны нөөцийн нэгдсэн менежмент-тэй болох, мэргэжилтэн сургаж бэлтгэх, бохирдсон хөрсийг яаж цэвэрлэх сэргээх, гэр хорооллын бохирын асуудлыг шийдэх арга зам, гүний усны бохирдлоос урьдчилан сэргийлэх боломжийн талаар өөрийн удирдаж буй төслийн талаар дэлгэрэнгүй, сонирхолтой илтгэл тавьсан. Төслийн хүрээнд нийт 18 сая евро Холбооны боловсрол, судалгааны яамнаас төлөвлөгдсөнөөс одоогоор 15 сая еврогийн төсөл хэрэгжээд байна.

**Проф. Др. Юрген Хофман**

**Гол мөрний гадаргын ус, загасны аж ахуйн экологийн тэнцвэртэй байдлын судалгааны Лайбниц Институт**

**Илтгэлийн нэр: Хараа голын сав газрын усны нөөц, түүний ашиглалт**

Проф. Др. Инж. Ш. Бүрэнгийн ахалсан Төв Азийн Усны нөөцийн нэгдсэн менежмент „Загвар бүс-Монгол“ судалгааны ажлын нэг хэсэг болох Хараа голын сав газарт чанарын судалгаа хийсэн талаар дэлгэрэнгүй илтгэл тавьсан.

**Фрайберг хотын Уул уурхайн академийн Оюутан Ө.Дуламжав ( 7-р курс )**

**Илтгэлийн нэр: Ил уурхайн хөрсний нөхөн сэргээлт**

Фрайберг хотын Уул уурхайн академид суралцаж буй оюутнуудаа төлөөлөн Монголын уул уурхайн салбарт ил уурхайн хөрсний нөхөн сэргээлтийн талаар тус



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und



Уул уурхайн академийн эрдэмтэн багш нар өмнө эхлүүлж байгаад түр зогсоосон судалгааг үргэлжлүүлэн хийж байгаа талаар илтгэл тавьсан.

Оюутан Ө.Дуламжав ихийг сурч бүтээх эрмэлзлэлтэй, эх орныхоо уул уурхайн салбарт бодитой хувь нэмэр оруулахын төлөө тодорхой зорилготой, санаачлагатай сурч байгаа тус Академийн оюутан залуучуудын бодит төлөөлөл болж байлаа.

## **Дип.Инж. Цолмон**

### **Германы ХЕОС компанийн төлөөлөгч**

Бага нуурт анх удаа нарны болон салхины хүчээр хослон тэжээл авдаг 15 кв чадал бүхий хибрид сэнсийг германы хөрөнгө оруулалтаар ашиглалтанд оруулсан тухай, дээрх сэнсийг малчдын хүүхдүүдэд зориулсан нүүдлийн гэр цэцэрлэгт ашиглах боломжийн талаар танилцуулсан.

## **Хишигсүрэн**

### **Бонтера Вейланд ХХК**

### **Илтгэлийн нэр: Хөрсний элэгдлийг хянах хучаас**

Уурхайн хөрсийг нөхөн сэргээх талаар германд хэрэглэж байгаа зарим туршлага, жишээ болгон бэлэн дэвсдэг хөрсөн хучаас талаар танилцуулсан.

Салбар хуралдаанд нийт 40 хүн оролцож дээрх илгэлүүд тавигдаж

–Газрын гадаргын болоод гүний усны нөөц хамгаалах

- Хот суурин газрын хөрсний бохирдлыг багасгах, бохирдлоос гарах арга зам
- Уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас үүдэлтэй гадаргын болоод гүний усны бохирдуулалт
- Ус цэвэрлэх ба байгалийн нөхөн сэргээлтийн талаар шинэ технологи, боломжууд





-Хөрсний бохирдолтыг зогсоох зорилгоор гэр хороолол ба төвийн нэгдсэн сүлжээгүй газарт зөөврийн авсаархан цэвэрлэгээний тоног төхөөрөмж хэрэглэх боломж зэрэг сэдвүүдээр дэлгэрэнгүй ярилцаж харилцан саналаа солилцов.

Проф. Ш. Бүрэнгийн хариуцан ажиллаж буй судалгааны төслийн хүрээнд германд боловсрол эзэмшсэн мэргэжилтэн шаардлагатай байгаа тул уул уурхай, ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгааллын чиглэлээр суралцаж байгаа оюутнууд дээрх төслийн ажилд хамрагдах боломж байгааг танилцуулав.

Германд сурч, ажиллаж, амьдарч байгаа монголчууд уул уурхай, ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгааллын чиглэлээр харилцан мэдээлэл туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дээрх чиглэлээр ажлын арвин туршлагатай Проф. Ш. Бүрэнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллах саналыг салбар хуралдаанд оролцогчид санал нэгтэй дэмжлээ.

Цаашид уул уурхай, ногоон хөгжил, байгалийн нөөцийн хамгааллын чиглэлээр эх орныхоо хөгжилд нэмэр болохуйц санаа, зөвлөмжийг дээрх ажлын хэсгээр хэлэлцсэний дараа нэгдсэн байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлж байхаар тохирсон болно.

Ц.Бат-Зангиа



Centrum für internationale Migration und Entwicklung  
eine Arbeitsgemeinschaft aus giz und 